

“ Жангар” ажлын хуудас

Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас

дүрийн өсөлтийг дүгнэх

Агуулгын товч тайлбар

Дүрийн холбоо хамаарал- Нэг дүр нөгөө дүрийн нөлөөллөөс хамаарч тодорхойлогдохыг хэлж байна.

Дүрийн өсөлт- Тухайн дүр өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд тохиолдож буй саад бэрхшээлийг даван туулж зовлон гунигийг ялж, зорилгодоо хүрэхийг дүрийн өсөлт гэнэ.


1. Жангарын дүрийн зорилгыг тодорхойлоорой.

Зорилго	Зорилгодоо хүрэх арга зам	Хүрсэн үр дүн

2. Жангартай холбоотой бусад дүрүүдийн хэлсэн үг, хийсэн үйлдлээс эш татан тэдний зан төрхийг тодорхойлоорой.


Хэн хэлсэн	Эшлэл	Зан төрх

3. Дүрүүдийн хооронд ямар холбоо хамаарал байгааг дүгнэн, үйл явдал өрнөхөд ямар үүрэгтэй байгааг тайлбарлан бичээрэй.



4. Гэсэрийн дүрийн өсөлтийг ажиглан Жангар туулийн дараах хэсгээс Жангарын дүрийг зорилгоор нь өсөлтийн графикт тэмдэглэ.

...Гэсэр мартсанаа сэрг, Арлан гоо хатны хамт нутагтаа ирэв. Шарайголын гурван хааныг сөнөөж, Рогмо гоо хатнаа автав, Цотон ноёныг шийтгэж, нутаг орноо тохинуулав... /Тавдугаар бүлгээс/



...Тансаг бумба хааны ач

Үйзэн алдар хааны хөвгүүн Жангар билээ

Эрхэн хоёр насандаа

Догшин мангаст нутгаа дайлуулж

Өнчин биеэр үлдсэн

Гурав хүрэх насандаа

Аранзал зээрдийн үрээ цагт

Хөл өргөж мордсон

Гурван их бэхлэлтийн амыг эвдэж
 Гулжин шар мангасыг номдоо оруулсан
 Дөрөв хүрэх насандаа
 Дөрвөн их бэхлэлтийн ам эвдэж
 Дөрвөн их шар мангас хааныг номдоо оруулсан...
 Долоотойдоо доордын долоон орныг доройтуулж
 Дуутай жангар нэрээ дуудуулсан... /Жангар туулиас

Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлах

Зохиолд өгүүлэгдэж буй юмсыг өгүүлэгдэхүүн гэнэ. Өгүүлэгдэхүүн нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй.

Эхлэл	Зохиолын өгүүлэгдэхүүний зөрчил үүсэх суурь дэвсгэр бүхий үйл явдлыг хэлнэ.
Зангилаа	Зохиолын үйл явдал үргэлжлэх, зөрчил мөргөлдөөн, үүсэх шалтгааныг хэлнэ.
Өрнөл	Зохиолын үйл явдал үргэлжлэх, зөрчил мөргөлдөөн, үүсэх шалтгааныг хэлнэ.
Туйл	Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл хурцдаж туйлдаа хүрэхийг хэлнэ.
Тайлал	Зохиолын зөрчил тэмцэл туйлдаа хүрч улмаар хэрхэн шийдэгдэж байгааг хэлнэ.
Төгсгөл	Зохиолын төгсгөлд баатруудын хувь заяа ямар болсон, зохиолч өөрөө хэрхэн үзсэн зэргээ илэрхийлснийг хэлнэ.

5. “Жангар” туулийн өгүүлэгдэхүүний бүтцийг гарга.

Эхлэл	
Зангилаа	
Өрнөл	
Туйл	
Тайлал	
Төгсгөл	

6. Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, өнгөрснийг дурсаж, ирээдүйг зөгнөж өгүүлсэн ямар хэрэг явдал гарч байгааг тайлбарлаарай.

Өнгөрснийг дурссан эшлэл-/А/, ирээдүйг зөгнөсөн эшлэлийг /Б/-үсгээр тэмдэглээрэй

Бүлгийн нэр	Өнгөрснийг дурссан \ А\, ирээдүйг зөгнөсөн \Б\ эшлэл	Ямар зорилгоор
Алтан Цээж, Жангар хоёрын байлдсан бүлэг	... хожим хойно өөрийнх нь орыг залгаж, ертөнцийг эзлэх их хүчтэн болохыг ... \Б\	Баатар зоригтой эр болох шинжтэйд айн, сүрдэж даруй устгахаар шийдсэн.